

Зүүн Хойд Азийн бүс нутагийн байгаль

орчны дадлага хөтөлбөр

东北亚地区环境体验活动

北東アジア地域環境体験プログラム

동북아시아지역 환경체험 프로그램

Симпозиум для школьников региона СВА

по приобретению экологического опыта



Сэдэв: Усны эх булгийг хамгаалах, бохирдлоос сэргийлэх арга хэмжээ

**2010 оны 8-р сарын 4 /пүрэв гариг/ нөөс 5-ны /баасан гариг/ хооронд
БНХАУ-ын Ляонин мужийн Дайлян хот**

Зохион байгуулагч:

БНХАУ-ын Ляонин мужийн байгаль орчныг хамгаалах яам, Япон улсын
Тояма мужийн амьдрал, байгаль орчин, соёлын газар

Зүүн Хойд Азийн бүс нутагийн байгаль орчныг хамгаалах дадлагын хөтөлбөр

8 сарын 3-ны өдөр, Мягмар гариг

Гадаадын оролцогч нар Хятад улсад орж ирэх

Гадаад дотоодын оролцогч нарын хамтарсан уулзалт (Дайлян хотын анагаахын их сургууль) руу явах

Хуралд оролцогчдыг бүртгэх

16:00-17:00 Бүс нутаг тус бүр болон сургууль тус бүрийн төлөөлөгчдийн хурал (газар: сургуулийн номын сангийн 2 давхарт хурдын танхимд) ерөнхий тайлбар, хурлын баримт бичиг, үйл ажиллагаанд оролцох хэрэгсэлийг тараах, үйл ажиллагааны хэрэгжилт болон аюулгүй байдлын тухай хэлэлцэх

17:00-17:30 Хурлын сайн дурын үйл ажиллагаа болох их сургуулийн багш нар сургуулийн кямпасыг танилцуулах ба үйл ажиллөгөө явуулах сургалтын байдлыг үзүүлэх

18:00- Хүлээн авалтын уулзалт

Маргаашийн бэлтгэл, унтах

8 сарын 4-ний өдөр, Лхагва гариг

Өглөөний унд (газар: их сургуулийн цайны газар)

8:30- Зүүн Хойд Азийн бүс нутагийн байгаль орчныг хамгаалах дадлагын хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаа

8:30-9:10 Мэндчилгээ (газар: сургуулийн номын сангийн 1 давхарт)

- БНХАУ-ын Ляонин мужийн Дайлян хот
- БНХАУ-ын Ляонин мужийн Дайлян хотын Байгаль орчныг хамгаалах газарын дарга Бингжие Ванг
- БНХАУ-ын Ляонин мужийн Дайлян хотын боловсролын газарын дэд дарга Юхүа Лию
- Япон улсын Тояма мужийн амьдрал байгаль орчин соёлын газар дэд захирал Такеши Хори

9:10-9:20 Оролцогчдын гарын үсэг

9:20-9:40 Дурсгалын зураг авахуулах

9:40-12:00 Үйл ажиллагааг эхлүүлэх мэдэгдэл (газар: сургуулийн номын сангийн 1 давхарт)

✚ Нэг дусал усны үнэ цэнэ, нэг дусал усыг хэмнэх үйл ажиллагаа (Ляонин муж) **【10】**

✚ Байгаль орчны судалгаа, өдөрлөг (Тояма муж) **【12】**

✚ Хөх мөнгө (Төв аймаг) **【13】**

- ✚ Байгаль орчныг хадгалж хамгаалах бячхан хамгаалагчдын Ээж нуурыг хадгалах үйл ажиллагаа (Хэйлунжиян) **【14】**
- ✚ Жинфү нуур дахь амьд организмд хийсэн судалгааны үйл явц ба байгаль орчны үйл ажиллагаа (Гангньюнг Мюнсёнг) **【15】**
- ✚ Хүний үйл ажиллагаа нь жижиг голд нөлөөлж байгаа тухай (Белая голд хийсэн судалгааг жишээ болгов) (Далайн хөвөөний бүс нутаг) **【17】**
- ✚ “Ногоон төгөл” эко клубын үйл ажиллагаа (Өвөрхангай аймаг) **【19】**
 Үдийн хоол (газар: их сургуулийн цайны газар)
- 14:00-16:00 Хурал: “Далайн байгаль орчны бохирдол ба түүнээс хамгаалах арга хэмжээ”
 газар: сургуулийн номын сангийн 1 давхарт) Нарэн Бао (Дайлян хотын байгаль орчныг хянах төвийн дээд түвшний багш, эрхлэгч)
- 16:00-17:00 Оюутнуудын тоглоом
 Оройн хоол (газар: их сургуулийн цайны газар)
- 19:00-21:00 Оролцогчдод гэрчилгээ олгох, дурсгалын зүйл гардуулах
 Маргаашийн байгаль орчны дадлагын үйл ажиллагааны бэлтгэл (Өрөө тус бүрээрээ далайд лонхон дотор байгаль орчныг хамгаалах тухай агуулгатай 100 м-ийн эвхмэл бичиг хийж тавих) (газар: сургуулийн номын сангийн 2 давхарт)
 Маргаашийн бэлтгэл, унтах

- 8 сарын 5-ны өдөр, Пүрэв гариг
 Өглөөний унд (газар: их сургуулийн цайны газар)
- 8:00- Люшүн Лоүтэшан руу явах (автобусаар)
 Байгаль орчны дадлагын үйл ажиллагаа (газар: Люшүн Лоүтэшан байгаль орчны хамгаалалтын бүс, Шар тэнгис болон Боохай тэнгисын хилийн зурвас)
 - Байгаль орчны тунхаглалын бичигийг танилцуулах
 - Орон тус бүрийн оюутнууд өөрсдийн орны хэлээр бичигдсэн байгаль орчны тунхаглалын бичигийг лонхонд хийж далайд тавих
 - Орон бүрийн оюутнууд байгаль орчныг хамгаалах 100 метрийн эвхмэл бичиг бүтээх
 Их сургуульруу буцах (автобусаар)
 Үдийн хоол (газар: их сургуулийн цайны газар)
- 13:00-14:00 Дайлян хотын Байгалийн түүхийн музей рүү явах (автобусаар)
- 14:00-16:00 Дайлян хотын Байгалийн түүхийн музей рүү үзэх
- 16:00-17:00 Байгаль орчинтой танилцах дадлага (газар: Шинхай талбай)
 - Хотын иргэд ба жуулчдад байгаль орчныг хамгаалах тухай эвхмэл бүтээлээ үзүүлж, эко, бага нүүрс төрөгч хэрэглэх амьдралыг

17:00-18:00 Их сургуульруу буцах (автобусаар)
Оройн хоол (газар: их сургуулийн цайны газар)

19:00-21:30 Хоорондоо харилцах
Нутаг буцах бэлтгэл, унтах

8 сарын 6-ны өдөр, Баасан гариг

Өглөөний унд (газар: их сургуулийн цайны газар)

Дайлян хотын анагаахын их сургуулиас явах (Дайлян хотын онгоцны буудал
болон автобусны буудалаас үдэлт хийх)


Илтгэлээс тусдаа үйл ажиллагааны материал

- Амур мөрөн болон Амур мөрөнд цутгадаг голын усан дахь химийн нэгдэлийн онцлог (Хаваровскийн бүс нутаг) **【21】**

Нэг дусал усны үнэ цэнэ, нэг дусал усыг хэмнэх үйл ажиллагаа

1. Бүсийн нэр: Ляонин муж
2. Илтгэгчийн нэр: Хинюи Лю (Дайлян хотын Люшүн 60-р дунд сургуулийн 2-р анги)
3. Үйл ажиллагааны нэр: Нэг дусал усны үнэ цэнэ, нэг дусал усыг хэмнэх үйл ажиллагаа
4. Хугацаа: 2009 оны 9-р сараас 2010 оны 3-р сар
5. Газар: Дайлян хотын Люшүн 60-р дунд сургууль, Люшюн дүүргийн байгаль орчныг хамгаалах газар
6. Хүний тоо: 50 хүн (12 хэсэгд хуваан үйл ажиллагаа явуулах)
7. Үйл ажиллагааг эхлүүлсэн нөхцөл байдал: Бид бүхэн Дайлян хот, Люшүн дүүрэг, 60-р дунд сургуулийн орчимд ус дутагдаж байгаа байдалыг интернэтээс судалж үзэн Люшюн дүүргийн байгаль орчныг хамгаалах газарын ажилтантай ярилцаж багцалсан. Түүний үр дүнд үндэслэн сургуулийн орчмыг судалгааны зорилго болгон сонгон авсны дотор ялангуяа суралцагчдад зориулсан усны крантын талаар усыг хэмнэж буй эсэх байдалыг шалгаж үзсэн. Улмаар судалгааны материалаа нэгтгэн дүгнэж нийтийн зориулалттай ус хэмнэх төхөөрөмжийг санал болгож, сургууль болон байгаль орчныг сурталчлах боловсролын төвийн оролцоотойгоор ус хэмнэх төхөөрөмжийг сурталчилсан.
8. Илтгэлийн агуулга:
 1. Байгаль орчинтой танилцах дадлагын хөтөлбөрийн тухай төлөвлөгөө болон менежмент
 2. Усыг хэмнэх нөхцөл байдлын талаарх судалгаа болон дадлагын үйл ажиллагаа
 3. Усны хэмнэлтийн төхөөрөмжийг санал болгох, сурталчлах (Сургууль болон байгаль орчныг сурталчлах боловсролын төвийн дэмжлэгтэйгээр)

Үйл ажиллагааны байдал (2009 оны 9 сараас 2010 оны 3 сар хүртэл) болон үр дүн

		
<p>Усыг хэмнэх тухай сурталчилгааны үйл ажиллагаа</p>	<p>Үйл ажиллагаанд оролцогчдын семинар</p>	<p>Дайлян хотын усны ундаргын талаарх судалгаа</p>



Хэмнэсэн усаараа цэцэг усалж тарих



Судалгаа хийж байгаа байдал



Судалгаа хийж байгаа байдал



Судалгааны үр дүнгээ гаргаж байгаа нь



Үйл ажиллагаанд оролцогчын сурталчилгаа



Ус хэмнэх үйл ажиллагаанд оролцогч

Байгаль орчны судалгаа, өдөрлөг

1. Бүсийн нэр: Тояма муж
2. Илтгэгчийн нэр: Цүтоми Итагава (Тояма мужийн Үозүгийн аж үйлдвэрийн мэргэжлийн ахлах сургуулийн байгаль орчны салбар сургууль)
3. Үйл ажиллагааны нэр:
 - 1) Агаарын бохирдолын судалгаа
 - 2) Голын усны чанарын судалгаа
 - 3) Хаягдал тосоор саван хийх
4. Хугацаа: Нэг жилийн хугацаанд
5. Газар:
 - 1)Тояма мужийн тухайн бүсийн замын дагуу
 - 2)Үозү хот доторх 3 гол
 - 3)Мужийн доторх олон төрлийн байгаль орчны талаарх өдөрлөг
6. Хүний тоо: 15 хүний бүрэлдэхүүнтэй
7. Үйл ажиллагааг эхлүүлсэн нөхцөл байдал: Байгаль орчны салбар сургуулийн үйл ажиллагааны нэг хэсэг болгож эхлүүлсэн.
8. Илтгэлийн агуулга: Байгаль орчны салбар сургууль нь 3 үндсэн үйл ажиллагааг явуулдаг. Энэ удаагийн илтгэлд эдгээрийг танилцуулъя.
 - 1) Зарүцүман химийн урвалын аргийг ашиглан агаар дахь азотын исэлийн өтгөрөлийг долоо хоног бүрт нэг удаа хэмжсэн. Бүлгийн гишүүд тус бүр харих замаа, бүс нутагийн гол газарт азотын хийг сорж авах бодис уусгасан цаас хийсэн үйлдвэрийн хэрэгсэлийн байрлуулж нэг өдөрийн дараа авч Зарүцүман химийн урвалын аргаар урвалд оруулж гэрлийн тусгалыг татдаг хэмжүүрээр хэмжиж азотын исэлийн өтгөрөлийг гаргах зүйл юм.
 - 2) Усны чанарыг шалгах тестийг ашиглаж усан дахь бодисын чанарыг шалгаж үзсэн. Тус сургууль байрладаг Үозү хот дахь 3 гол болох Катакай гол, Камокава, Кадокава голуудад ээлж дараалан усны шинжилгээг хийж, усан дахь фосфор, аммиак, рН зэрэг олон төрлийн зүйлийг шинжилж байна.
 - 3) “Газар дэлхий Тояма”, Үозүгийн хотын байгаль орчны фестивал” “Тояма байгаль орчны үзэсгэлэн худалдаа” зэрэг мужийн байгаль орчны өдөрдөгүүдэд оролцож “Хуванцар савыг ашигласан хаягдал тосыг дахин боловсруулж саван гаргаж авах” туршилтийн өрөө байгуулж үзэж сонирхохоор ирсэн хүмүүст тухайн газар хаягдал тосоор саван хийлгэх үйл ажиллагаа явуулж байна. (зураг)



Хөх мөнгө

1. Бүсийн нэр: Төв аймаг
2. Илтгэгчийн нэр: Баярсайхан Золжаргал (Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургуулийн 10Г ангийн сурагч)
3. Үйл ажиллагааны нэр: Усны нөөцийг хянах сургалт
4. Хугацаа: 2010 оны 1 сараас 6 сар хүртэл
5. Газар: Улаанбаатар хот, Туул гол
6. Хүний тоо: 3 хүн
7. Үйл ажиллагааг эхлүүлсэн нөхцөл байдал: Ойрын ирээдүйд Монголын цэвэр тунгалаг гол мөрний ус ширгэх аюултай тулгарч байгаа тул Монголын газар зүйн сурах бичигээс суралцахын зэрэгцээ, 2007 онд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Усны нөөцөд хяналт тавих арга хэмжээ” гэсэн сэдэвт хуралд илтгэгдсэн илтгэлээс суралцсан.
8. Илтгэлийн агуулга: Аяга ус алтнаас илүү үнэтэй гэвэл та итгэх үү.

Ихэнхи хүн “Хар ус хэзээ алтнаас үнэтэй болчихсон юм бэ” хэмээн хэлэх биз ээ . . . Гэвч өнөөдөр хорвоогийн тоосыг хөдөлгөж яваа амьтай бүхэн цэнхэр алтаар нөхөн тэжээгддэг. Хүн хоолгүй хэд хонож чадах ч усгүй бол таван хоног ч тэсвэрлэхгүй. Ингээд бодохоор ус гэдэг асар үнэтэй эрдэнэ мэт. Гэвч өнөөдөр үүнийг ухамсарлаж, усаа хайрлаж байгаа хүн хэд билээ.

Орон сууцанд тухлах “эрх”-үүд шүдээ угаахдаа хэдэн арван литр ус ямар ч үр ашиггүй урсгадаг. Уг нь тэд шилэн аяганд ус тасалж аваад хэрэглэхэд ганц хором л зарцуулана шүү дээ. Гэвч залхуурдаг нь харамсалтай. Энэ нь тэд ирээдүйгээсээ амьдралыг нь тэтгэгч чандмань эрдэнийг хулгайлж буй хэрэг юм. Монгол Улс усны нөөцөөр хомс орны тоонд ордог. Манайх 599 шоо км усны нөөцтэй. Бид хэрэглээний 80 хувийг гүний, үлдсэнийг нь гадаргын усаар хангадаг. Өнөөдрийн байдлаар бид усны нөөцийнхөө 0.5-0.7 шоо км-ийг ашиглаад байгаа аж.

Энэ бага санагдаж байж болох юм. Гэвч замбараагүй хэрэглээ үргэлжилсээр байвал 2020 он гэхэд манай улс цэвэр усны хомсдолд орж болзошгүй тухай эрдэмтэд анхааруулжээ. Манай улсын хувьд ус хэрэглэгчдийг дотор нь гэр хорооллын хэрэглэгчид, болон орон сууц, үйлдвэрийн хэрэглэгчид хэмээн ангилж байна. Усны хэрэглээгээрээ орон сууцны айл өрхүүд дийлэнх жинг эзэлдэг. Өөрөөр хэлбэл, тэд нийт хэрэглэж буй усны 73 хувийг хэрэглэдэг байна. Харин гэр хорооллынхон хоёрхон хувийг л хэрэглэдэг аж.

Манай улс 2004 онд усны тухай хуулиа шинэчилсэн. Үүний үр дүнд 2005 онд Засгийн газрын тогтоолоор усны нөөц ашиглалтын төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулж, улмаар усны хэт үрэлгэн байдал бага ч болтугай буурсан статистик судалгаа гарсан юм.

Сүүлийн үед гадаргын ус хомсдож байгаа. Энэ нь хоёр шалтгаантай аж. Юуны өмнө дэлхийн дулаарал үүнд нөлөөлж буй. Түүнчлэн, ойн нөөц хомсдоноос үүдэлтэй юм. Ой хөвч усыг хадгалж байдаг.

Мөн 1990 оноос усны шинэ хэрэглээ гарч ирсэн. Тухайлбал, Манай оронд алтны уурхайнууд олноор бий болж тэдний өдөр тутмын үйл ажиллагаа устай салшгүй холбоотой учир усыг маш ихээр хэрэглэнэ. Үүний улмаас гол, мөрөн ширгэж, усны нөөц хомсдож байна.

Манай улс усны хэрэглээнийхээ бараг 90 хувийг газрын доорхи усаар хангадаг байна. Гэтэл газрын доорхи ус нь экологийн нэн эмзэг тогтоцтой, нөхөн сэргэх хугацаа нь хэдэн зуун жил үргэлжилдэг болохоор усыг нөхөн сэлбэгдэх хэмжээнээс нь хэтрүүлэн ашиглах ёсгүй. Иймд бид бүгд байгаль дэлхийгээ нэгэн сэтгэлээр хайрлан, хамгаалж усныхаа хэрэглээг багасган эрүүл аюулгүй орчинд амьдарцгаая.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

**Байгаль орчныг хадгалж хамгаалах бячхан хамгаалагчдын
Ээж нуурыг хадгалах үйл ажиллагаа**

1. Бүсийн нэр: Хэйлунжиян
2. Илтгэгчийн нэр: Жян Ю Нин (Харвин хотын 47-р дунд сургуулийн 2-р ангийн 7-р бүлэг)
3. Үйл ажиллагааны нэр: Байгаль орчныг хадгалж хамгаалах бячхан хамгаалагчдын Ээж нуурыг хадгалах үйл ажиллагаа
4. Хугацаа: 2010 оны 4-р сарын сүүлээс 5-р сарын сүүл
5. Газар: Харвин хот дахь ногоон бүсийн 12 сургууль
6. Хүний тоо: 6000 хүн
7. Үйл ажиллагааг эхлүүлсэн нөхцөл байдал, Илтгэлийн агуулга:
 - 1- р алхам: Харвин хот дахь ногоон бүсийн 12 сургуульд “Байгаль орчныг хадгалж хамгаалах бячхан хамгаалагчдын хүсэлт” гэсэн 6000 ширхэг тараах материал тарааж, 3 дахь сэдэвтэй холбогдох үйл ажиллагааг сурагчдад танилцуулсан.
 - 2- р алхам: Байгаль орчныг хадгалах хамгаалах талаар том хэмжээний өдөрлөг зохион байгуулж, өдөрлөгт шалгарсан бүтээлд шагнал гардуулах үйл ажиллагаа зохион байгуулсан. Мөн хэд хэдэн олон талт үйл ажиллагааг төлөвлөсөн.
 - 3- р алхам: “Байгаль орчны боловсролын хичээлийг их сургуульд оруулах” гэсэн хөдөлгөөн өрнүүлж хот доторх 12 ногоон бүст сургуульд “Ээж нуурийг хайрлацгаая” гэсэн сэдэвээр тусгай лекц зохион байгуулсан.

Жинфү нуур дахь амьд организмд хийсэн судалгааны үйл явц ба байгаль орчны үйл ажиллагаа

1. Бүсийн нэр: Гангньюнг Мюнсёнг
2. Илтгэгчийн нэр: Еонг-Ванг Чо
(Гангньюнг Мюнсёнг ахлах сургуулийн) Тасари дугуйлан
3. Үйл ажиллагааны нэр: Жинфү нуур дахь амьд организмд хийсэн судалгааны үйл явц ба байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа
4. Хугацаа: 2006 оны 3-р сараас 2010 оны 6-р сар
5. Газар: Жинфү нуур, Хянхо, Анин далайн хөвөөний элс, Жанлин хотын хүүхэд залуусын сурган хүмүүжүүлэх төв зэрэг Жанлин хотын бүх дүүрэг
6. Хүний тоо: 40-50 хүн
7. Үйл ажиллагааг эхлүүлсэн нөхцөл байдал: Жинфү нуур нь ойролцоогоор 3000 жилийн өмнө бий болсон давстай нуур юм. Далайн ус болон цэвэр ус холилдон давсархаг устай нуур хэмээгдэж ховор амьд организм байдаг түүхийн, соёлын хувьд ч хадгалагдах үнэлэмж өндөртэй газар юм. Мөн нүүдлийн шувуудын хооллодог газар болдог ба нүүдэллэх үедээ ч түр буудаг газар нь болдгоороо байгаль орчноо хамгаалах өнцөгөөс чухал үүрэг гүйцэтгэж байна. Иймээс хүүхэд залуус бидний хүчээр In Our Hands – Байгаль орчноо хамгаалах нь бидний хүч чадалаар- гэсэн уриа гаргаж Жинфү нуурыг хамгаалахын тулд хүн байгаль орчинтой харилцан хамааралтай амьдрах гэсэн утгаар Тасари дугуйланг байгуулж үйл ажиллагаагаа эхлүүлэх болсон.
8. Илтгэлийн гол агуулга: Гангньюнг Мюнсёнг ахлах сургуулийн дугуйлан Тасаригийн танилцуулга
 - Үүсэн байгуулагдсан хугацаа: 1995 онд Гангньюнг Мюнсёнг ахлах сургуулийн “Байгаль орчны хяналтын баг” гэсэн нэртэйгээр үйл ажиллагаагаа эхэлж 2000 оноос байгаль орчин ба хүн хамтдаа амьдарцгаая гэсэн утгаар “Тасари” гэсэн нэртэй болж өөрчлөгдөн албан ёсоор байгаль орчноо хамгаалах үйл ажиллагаагаа эхлүүлсэн.
 - Үйл ажиллагаанд оролцогчдын тоо:
 - 2000-2009 оны байдлаар 1-р курст ойролцоогоор 15 хүн, 2-р курсын ойролцоогоор 20 хүн, 3-р курст ойролцоогоор 15 хүн болж дунджаар 45-50 хүний бүрэлдэхүүнтэй болсон.
 - 2010 оны байдлаар 1-р курст 23 хүн, 2-р курст 14 хүн, 3-р курст 13 болж нийт 50 хүн оролцож байна.
 - Үйл ажиллагааны агуулга:
 - Байгаль орчинтой танилцах дадлага хөтөлбөрийн менежмент
 - Бага нүүрс төрөгч ба ногоон ургамалын үржүүлэлт хийхийн тулд янз бүрийн

сургалтын материал боловсруулах ба дэлгэрүүлэх

- Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны цаашдын явц: Залуусаар чийгшилтэй газар байгуулуулах үндэсний найдварт хөдөлгөөний тархалт

Хавсралт: Үйл ажиллагааны танилцуулга

1. 2006 оны үйл ажиллагааны агуулга ба үр дүнгийн байдал

		
Жинфү нуур орчмыг цэвэрлэх хөдөлгөөн	Байгаль орчны өдөрөөр шагнал авсан	Жинфү нуурын амьд биеийн судалгаа

2. 2007 оны үйл ажиллагааны агуулга ба үр дүнгийн байдал

		
Жинфү нуурын амьд биеийн судалгаа	Жинфү нуур орчмыг цэвэрлэх хөдөлгөөн	Тайан хойгийн тос цэвэрлэх

3. 2008 оны үйл ажиллагааны агуулга ба үр дүнгийн байдал

		
Жинфү голд салмон загас хийсэн хөдөлгөөн	Жинфү нуур орчмыг цэвэрлэх хөдөлгөөн	Байгаль орчноо хамгаалахад уриалсан хөдөлгөөн

4. 2009 оныүйл ажиллагааны агуулга ба үр дүнгийн байдал

		
<p>Амьд организмын судалгааны үйл явцын тухай баримтат кино бүтээсэн</p>	<p>Байгаль орчноо хамгаалахад уриалсан хөдөлгөөн</p>	<p>Байгаль орчноо хамгаалахад уриалсан хөдөлгөөн</p>

5. 2010 оныүйл ажиллагааны агуулга ба үр дүнгийн байдал

		
<p>Байгаль орчны тухай үзэсгэлэнгийн нээлт</p>	<p>Байгаль орчноо хамгаалахад уриалсан хөдөлгөөн</p>	<p>Жинфү нуур орчмыг цэвэрлэх хөдөлгөөн</p>

Хүний үйл ажиллагаа нь жижиг голд нөлөөлж байгаа тухай (Белая голд хийсэн судалгааг жишээ болгов)

1. Бүсийн нэр: Далайн хөвөөний бүс нутаг
2. Илтгэгчийн нэр: Олига Гарвалинск (Дальнереченск хотын 2-р сургуулийн 11-р анги)
3. Үйл ажиллагааны нэр: Хүний үйл ажиллагаа жижиг голд нөлөөлж байгаа тухай баримтаг судалгаа, сонин сэтгүүлийн мэдээнээс хийсэн усны шинж чанарын судалгаа, физик химийн болон бичил биеийн задлан шинжилгээгээр усны шинж чанарт хийсэн судалгаа, Белая голын өөрчлөлт болон амралт зугаалгын газар болгож ашиглах талаарх санал асуулгын судалгаа
4. Хугацаа: 2009 оны 4-6-р сар
5. Газар: Далайн хөвөөний бүс нутагийн баруун хойд хэсэгт байрлах Дальнереченск хотын дундуур урсах Белая гол
6. Хүний тоо: 1 оюутан, 3 багш
7. Үйл ажиллагааг эхлүүлсэн нөхцөл байдал: Хүний үйл ажиллагаанаас болж бохирдсон гол нь хотын өнгө үзэмжийг дарж, бороотой өдөр голын ойролцоох дүүргүүд усанд автаж улмаар янз бүрийн өвчин үүсэх шалтгаан болж байна. Гэвч гол нь хотын хүн амын амралт зугаалгын бүс болох боломжтой. Иймээс Белая голтой холбоотой судалгааг эхлүүлсэн.
8. Илтгэлийн агуулга:

Дальнереченск хот нь далайн хөвөөний бүс нутагийн баруун хойд хэсэгт байрладаг, Большая Уссурка голын зүүн эрэгт Уссури голын цутгалаас 5 км-ын зайтай байдаг. Дальнереченск хот нь бусад далайн эргийн хотуудтай адил дулаан бүсийн цаг уурт хамрагддаг бөгөөд япон тэнгисээс алслагдсан тул эх газарын цаг ууртай. Жилийн дундаж температур -1,5 хм, уур манангүй өдөр 137 өдөртэй. Жилд буух усны хэмжээ 600 мм, түүний хагас нь зуны сүүлээр ордог.

Большая Уссурка голын урсгал ташуулдаж урссан урсгал ихтэй, чийгшил ихтэй учир голын дагуух нам дор газар нь намагшил ихтэй, олон тооны нууртай. Большая Уссурка голын зүүн урсгал болох Белая гол нь Дальнереченск хотын дундуур урсдаг юм. Белая гол нь хотын зүүн урдах намагийг усаар хангадаг. Голын урт нь 2,3 км, өргөн нь 2-5 м. Гол нь нурамтгай газараар урсдаг. Голын эрэг нь намхан.

Голд ихэвчлэн борооны ус урсдаг бөгөөд цас хайлж урсах ба газар доорх ус ч урсдаг. Голын урсгалын хурд нь 0,002-0,5 м/с. Голын усны дулаан нь 2 хм-ээс 23-25 хм хүртэл өөрчлөгддөг ба эрэг хавиараа дулаан нь нэмэгдэх газар байдаг. Өвөл голын ихэнх хэсэг бүхэлдээ хөлддөг. Голын усанд амьдардаг амьд амьтны төрөл цөөн, голдуу авгалдай, уст хорхой, бактери, соно зэрэг амьдардаг.

Далайн хөвөөний бүс нутагт үер болох нь ховор зүйл биш юм. 1901 оноос Дальнереченск

хотын усны үертэй холбоотой мэдээлэл сонинд нийтгэгдэх болсон. 1967 оны 8-р сард том хэмжээний үер болсон. Белая голын усны түвшин хэдэн метр хүртэл нэмэгдэж хотын төв хэсэг бүхэлдээ усанд автаж хотын иргэд гудамжаар завиар явж байсан. Үерийн хохирлыг арилгасны дараа Большая Уссурка голоос Белая голд ус цутгахаас хамгаалж усны хаалт байгуулсан. Хотын дотор далан болон усны түвшинг хянах төхөөрөмж байгуулж, хотын төвд ус орж ирэхгүй байхаар голын эргийг өндөргөсөн. Үүний үр дүнд Дальнереченск хот үерийн аюулаас хамгаалагдсан.

Усны хамгамжийн хэмжээ хангалтгүй болсон Белая гол гүехэн болж хотын иргэд голд анхаарлаа хандуулахаа больсон. Зун их хэмжээний бороо орох үед усны түвшин ихсэж ойролцоох иргэдийн гэр болон тариа ногооны газар усанд автдаг.

Удаан жил Белая голын дагуу амьдарч буй иргэд, аж ахуйн нэгж нь янз бүрийн хогийг голд хаяж байна. 1980-аад онд аж үйлдвэр, сургууль, байгууллага нь Белая голын эрэг орчмыг цэвэрлэдэг байсан ч түүнээс хойш энэ арга хэмжээ авагдахаа больсон. Өнөөгийн байдлаар голтой ойролцоох аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа нь Дальнереченск хотын байгаль орчныг хамгаалах байгууллагын хяналт дор явагдаж байна. Гэвч судалгаанаас үзэхэд голын эрэг хавь гэр ахуйн хог хаягдлаар дүүрэг байгаа нь тогтоогджээ. Голын ус нилээд хэмжээгээр бохирдож усны шинж чанар нь эрүүл ахуйн чанарыг хангахаа больсон байна. Мөн физик химийн ба бичил биетний судалгаагаар химийн бодис нь байх ёстой хэмжээнээсээ давсан байна. Судалгааны дүнд доорх арга хэмжээ авахыг санал болгож байна. Үүнд:

1. Голын цэвэрлэж, усны гүнг 2 м болгох
2. Хатуу биет хог хаягдал болон гэр ахуйг хог хаягдлыг авч хаях
3. Белая голын асуудлыг мэдээллийн хэрэгслээр зарлаж анхаарал хандуулах
4. Голын эрэг орчим ногоожуулалт зүлэгжүүлэлт хийж нөхөн төлжүүлэх
5. Иргэдийг усанд автахаас сэргийлэхийн тулд даланг 0,5-1 м өндөрсгөх, усны түвшинг хянах төхөөрөмжөөр усны түвшинг хянаж байх
6. Новая гудамжийн гараж орчмын газар болон Таврическая гудамжийн дагуух газарыг 610м-ын өргөнтэй далангаар холбох

Үүнээс гадна амралт зугаалгын газар байгуулах хэрэгтэй. Үүний тулд халуун усны газарын орчмыг зохицуулж, хотын төв цэцэрлэгтэй хамт халуун усны орчмыг иргэдийн амрах газар болгож ашиглах нь зүйтэй. Баригдаж буй зочид буудалаас гол хүртэл явах зам тавьж, голын эрэгт наран шарлагын газар байгуулах болон гэрэлтүүлэг хийх хэрэгтэй. Голын гүний ус хангалттай бол завь, 2 биет завь тавьж болно. Эдгээр ажил нь зардал шаардагдах боловч оюутан, хотын иргэдийн байгууллагын тусламж авч болно. Зуны улиралд Дальнереченск хотод ирэх жуулчдыг завинд суулгавал түүгээр орлого олох боломжтой.

“Ногоон төгөл” эко клубын үйл ажиллагаа

1. Бүсийн нэр: Өвөрхангай аймаг
2. Илтгэгчийн нэр: Ц.Содномдорж (Арвайхээр сумын 1-р сургуулийн)
3. Үйл ажиллагааны нэр: “Ногоон төгөл” эко клубын үйл ажиллагаа
4. Хугацаа: Нэг жилийн хугацаанд
5. Газар: Арвайхээр сум
6. Хүний тоо: 32 хүн
7. Үйл ажиллагааг эхлүүлсэн нөхцөл байдал, Илтгэлийн агуулга:

Сайн байцгаана уу? Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Зүүн хойд Азийн орнуудын “Байгаль орчныг хамгаалах хүүхэд залуучуудын чуулга уулзалт”-д өөрийн аймгаа “Ногоон төгөл” эко клубээ төлөөлөн оролцож байгаадаа баяртай байна. Өвөрхангай аймгийн Ерөнхий боловсролын 11 жилийн 1-р дунд сургуулийн “Ногоон төгөл” эко клуб нь анх 2007 онд сурагчдын санаачлагаар 16 гишүүнтэйгээр байгуулагдсан хүүхдүүдийн оролцооны байгууллага юм. Одоо 32 гишүүн, 1300 гаруй дэмжигч, 2 чиглүүлэгч багштайгаар үйл ажиллагаагаа явуулдаг.

Манай клубын зорилго нь: Найз нөхөд, анги хамт олон, иргэдэд байгаль орчноо хайрлан хамгаалах чиглэлээр сургалт сурталчилгаа хийх, цөлжилт элсний нүүдлийг багасгахад өөрсдийн хувь нэмрээ оруулж мод, цэцэг тарих, хүрээлэн буй орчноо хог хаягдалгүй цэвэр цэмцгэр байлгах зорилгоор үйл ажиллагаагаа явуулдаг.

“Ногоон төгөл” эко клубын хийж буй ажлууд: Үе тэнгийн сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулдаг: “Ногоон төгөл” эко клубын сурагчид аймгийнхаа Байгаль орчин аялал жуулчлалын газар, клубын удирдагч багштайгаа хамтран “Ногоон орчин бүрдүүлэхэд сурагч бидны оролцоо” сэдэвт сургалтыг 2009 оны 04 сарын 17-оос 05 сарын 20 хүртэл хугацаанд зохион байгуулсан. Сургалтанд хамрагдсан хүүхдүүд байгаль орчноо хамгаалах уламжлалт зан заншлыг ойлгож, мод, цэцэг тарихын ач холбогдлыг сурталчлан таниулах сургалт дадлагын үр дүнд сурагчид мод, цэцэг тарьж арчилах талаар найз нөхөд, анги хамт олондоо зааж үлгэр дуурайлал үзүүлэх чадвартай болсон. Мөн Өвөрхангай аймгийн төв Арвайхээр хотын гэр хороололд амьдардаг 400 гаруй иргэдэд 2009 оны 07 сарын 02-09 сарын 25 хүртэл хугацаанд “Эрүүл орчныг иргэн та бүрдүүлнэ сэдэв”-т сургалтыг хоёр үе шаттай зохион байгуулсан. Тус сургалтын хүрээнд энгийн бие засах газар, бохир усны цооногийн ариун цэвэр, ундны усны эрүүл ахуйн чиглэлээр нийт 72 цагийн сургалтыг зохион байгуулсан. Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой, эрүүл аюулгүй орчинд амьдрах чиглэлээр санаачлагатай оролцсон өрхүүдэд энгийн бие засах газар, бохир усны цооногийг тухайн газар оршин суугаа иргэдийн оролцоотойгоор тохижуулсан.

“Мянган цэцгийн баяр” нэгдсэн арга хэмжээг сургуульдаа зохион байгуулав:

“Мянган цэцгийн баяр” нэгдсэн арга хэмжээг 2009 оны 09 сарын 28-нд зохион байгуулсан. Цэцгийн баярт аймгийн Ерөнхий боловсролын 11 жилийн 1-р дунд сургуулийн нийт 40 бүлгийн, 2400 сурагч, 76 багш, 1300 гаруй эцэг эхчүүдийн төлөөлөл хамрагдсан. “Мянган цэцгийн баяр” нэгдсэн арга хэмжээнд нийт 2538 цэцэг тавигдсанаас “Хамгийн гоёмсог цэцэг”, “Хамгийн ховор цэцэг”, “Хамгийн олон төрлийн цэцэг” тарьсан анги хамт олныг шалгаруулж олон нийтэд сурталчилсан.

Хоггүй цэвэр орчин аяныг зохион байгуулдаг: Тус аяны хүрээнд “Хаяагүй л бол хог биш” сэдэвт сургалт, “Юмнаар юм хийе” сэдэвт хоёрдогч түүхий эдээр хийсэн бүтээлийн уралдаан, “Хамгийн гоё хийцтэй хогийн савийг хэн сайн хийх вэ” сэдэвт уралдааныг тус тус зохион байгуулсан. Хог хаягдлаа ангилан ялгахдаа үнэтэй сав авалгүй хаягдал цаасаар хогийн сав хийснээр эдийн засгийн хувьд ашигтай байсан. Мөн байгаль орныг хайрлан хамгаалах, Хүрээлэн буй орчны бохирдол түүний шалтгаан, хүний сүйтгэл ул мөрийг багасгах арга зам, энэ үйл ажиллагаанд хүүхэд бидний оролцоо гэсэн сэдвүүдээр гар зураг, илтгэлийн уралдаан, асуулт хариултын тэмцээнүүдийг тогтмол зохион байгуулдаг.

“Ногоон төгөл” эко клубын цаашид хийх ажлууд: Хүрээлэн буй орчноо хамгаалах, нөхөн сэргээхэд үе тэнгийн хүүхдүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хүүхдүүдийн дадал, хандлагыг өөрчлөх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлуудыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үе шаттайгаар тогтмол зохион байгуулах. Клубын үйл ажиллагаагаа өргөжүүлж орон нутагтаа эко клубын сурагчдын сүлжээ бий болгох зорилго тавьсан. Иймд орон нутагтаа төдийгүй улс, бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах алсын хараатай ажиллаж байна.

Амур мөрөн болон Амур мөрөнд цутгадаг голын усан дахь химийн нэгдлийн онцлог

1. Бүсийн нэр: Хабаровскийн бүс нутаг
2. Илтгэгчийн нэр: Александр Соболевский (Хабаровский хотын байгаль орчин ургамал амьтан судлалын төв)
3. Үйл ажиллагааны нэр: Амур мөрөн болон Амур мөрөнд цутгадаг голын усан дахь химийн нэгдлийг шинжилсэн судалгаанд оролцсон тухай
4. Хугацаа: 2008-2009 он
5. Газар: Хабаровск хот
6. Хүний тоо: 2
7. Үйл ажиллагааг эхлүүлсэн нөхцөл байдал: Амур мөрний бохирдолд санаа зовсны уламаас уг үйл ажиллагааг эхлүүлсэн.
8. Илтгэлийн гол агуулга:

Ан агнуур, загасны аж ахуй нь амьдралын гол үндэс болсон Хабаровскийн бүс нутагийн иргэд жил ирэх бүр цэвэр ус багасаж байгаад санаа зовж байна. Амур голоос салаалсан Казакевичева салаа гол нь Үсүри голтой нийлж Амур мөрөнд цутгаж байгаа тул Амур мөрний усны бүтэцэд муу нөлөө үзүүлж байна.

Хабаровск хот байгуулагдсанаас хойш усны нөөцийг Амур голоос нийлүүлдэг тул усны чанарыг цухалчилдаг байсан. 1907 онд анхны усны хоолой тавигдсан. Амур мөрний эргийн ойролцоо хүн ам өсөлт болон нуур цөөрөм, нөөцийн худагийн байгууламж зэргийн эдийн засгийн өөрчлөлт нь Амур мөрний усны чанарт муу нөлөө үзүүлсээр байна. Ийм учираас Амур мөрний бэлчирт усны чанарын хяналт шинжилгээ болон байгаль орчны арга хэмжээг яаралтай авах шаардлагатай болж байна.

20-р зууны сүүлд хийсэн судалгаагаар Амур мөрний бэлчирт маш бага хэмжээний аммиак, хлорын ион агуулагдаж байсан. Мөн усны жилийн дундаж минералийн хэмжээнд өөрчлөлт орж их үедээ 88,0мл хүрч байсан.

2008-2009 онд Оросын аюулгүй байдлын яамны туршилтын танхимд явуулсан задлан шинжилгээгээр Амур мөрний усны чанар аммиак ион, фенол карбоны хүчил, хөнгөн цагаан, төмөр, мангааны өтгөрөл нь хамгийн их байх хэмжээнээсээ давж нилээд муудсан.

Ойрын жилд ус ууж чадахгүй, усанд орж ч чадахгүй болсон Амур мөрний усны чанар санаа зовоосон асуудал болж байна. Мацүханаэ голын ай савд өнгөрсөн 30-40 жилийн хугацаанд эдийн засгийн үйл ажиллагаа эрчимжсэний улмаас Амур мөрөн болон Амур мөрний бэлчирийн усны чанарыг маш ихээр бохирдуулж байна. Үүний үр дүнд Амур мөрний бэлчирийн хэсгийн бодисын хуваарилалт нь нилээд тэнцвэргүй болж минералын байх ёстой хэмжээ нь зүүн эрэг орчимдоо их, баруун эрэгтээ бага болох байдал харагдаж байсан.

Үүн дээр Амур мөрний ай сав дахь бодисын олон төрлийн хэлбэруилтийг хамгаалах нь олон улсын түвшиний чухал асуудал болж байна. Учир нь Амур голын загасны төрөл нь Оросын хамгийн том гол Волга мөрнөөс олон байдаг юм. (Амур мөрөнд 103 төрөл, Волга мөрөнд 70 төрөл)

Үүнтэй холбоотойгоор Хабаровскийн бүс нутаг, Хабаровск хот, Амур мөрний ай сав гэсэн 3 түвшинд Амур голын усны чанарыг сайжруулахын тулд арга хэмжээ төлөвлөгдөөд байна. Дараах хойч үеийнхээ тулд голоо хадгалан үлдээх нь бидний үүрэг юм.

2010 Дайлян хотын байгаль орчныг хадгалах тухай тунхаг бичиг

“Зүүн Хойд Азийн бүс нутагийн байгаль орчны дадлага хөтөлбөр” –т оролцсон 5 орны залуус бидний байгаль орчныг хамгаалах талаар санал бодол болон мэдээлэл солилцох үйл ажиллагаа маань өргөжиж, биднийг хүрээлэн буй орчинд дадлага явуулснаар байгаль орчныг хамгаалахын чухалыг ойлгож энэ талаар бодох болсон. Ингээд байгаль орчны асуудлыг шийдвэрдэхийн тулд байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатайг ойлгосон .

Түүнчлэн байгаль орчныг хадгалах талаарх жижиг үйлдэл ч хувь хүн, бүс нутаг, улсын хил даван хоорондоо холбогдсон олон оролцогчтой болсон болохоор энэ нь Зүүн Хойд Азийн бүс нутагийн байгаль орчныг хамгаалах том урсгал болохыг анзаарсан.

Өнөөдөр “Зүүн Хойд Азийн бүс нутагийн байгаль орчны дадлага хөтөлбөр”-т оролцсон бид бүхэн Зүүн Хойд Азийн бүс нутагийн эрүүл байгалийг хадгалахын тулд өөрсдөө байгаль орчноо хадгалах үйл ажиллагаанд идэвхтэй оролцох төдийгүй Зүүн Хойд Азийн ард иргэд та бүхнийг ч уриалан дуудаж, та бүхэнтэй хамтдаа байгаль орчноо хадгалах үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхийг Ляонин мужид тунхаглаж байна.

Зүүн Хойд Азийн ард иргэдээ, бидэнтэй хамтран үйл ажиллагаанд оролцоцгооё.

2010 оны 8-р сарын 5-ны өдөр

“Зүүн Хойд Азийн бүс нутагийн байгаль орчны дадлага хөтөлбөр” –т оролцогчид